



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/74

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутагт соёл, аялал жуулчлалын томоохон эвентийг бий болгож нутагшуулах зорилгоор тогтмолжуулж буй “Цааны баяр-2024” соёлын наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Батцэцэг (Соёл урлагийн газрын дарга)
Гишүүд: П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
Ч.Дашбаяр (Гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын газрын дарга)
Ш.Отгон-Эрдэнэ (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
Б.Содномпилжээ (Хатгал тосгон дахь сум дундын цагдаагийн тасгийн дарга)
Т.Галсайхан (Хөгжимт драмын театрын үйлдвэр ангийн дарга)
Д.Дуламсүрэн (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
Б.Цэрэн-Очир (Цагааннуур сумын Засаг дарга)
С.Өлзийсайхан (Цагааннуур сумын 2-р багийн Засаг дарга)
Я.Эрдэнэжав (Цагааннуур сумын байгаль орчны байцаагч)
Ч.Оюунбадам (Цагааннуур сумын ЕБС-ийн захирал)
Т.Цэндмаа (Цагааннуур сумын СӨБ-ийн эрхлэгч)
М.Оюун (Цагааннуур сумын соёлын төвийн дарга)
Б.Ганбаатар (Хөвсгөл аймгийн Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны тэргүүн)

Соёл урлагийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ

Нарийн бичгийн дарга: Х.Баасансүрэн (Соёл урлагийн газрын мэргэжилтэн)

2.“Цааны баяр-2024” соёлын наадмыг зохион байгуулах удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батцэцэг)-д, үйл ажиллагааг өндөр түвшинд, үр дүнтэй зохион байгуулж хамтран ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Соёлын наадам зохион байгуулахтай холбоотой зардлын тооцоог нарийвчлан гаргаж 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батцэцэг)-д, наадмыг чанартай зохион байгуулж, үйл ажиллагааны тайланг 2024 оны 03 дугаар сарын 15-ны дотор гаргаж ирүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Х.Баасансүрэн)-д үүрэг болгосугай.

6717010244

4. “Цааны баяр-2024” наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж олгох 25.000.000 (хорин таван сая) төгрөгийг эвент арга хэмжээ зохион байгуулах зардлаас гаргахыг Засаг Даргын Тамгын Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ